

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Зохиолыг анхааралтай уншиж, ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Өнө мөнхийн хэлхээ

Зуны дунд сард хангай дэлхий үзэсгэлэнгийнхээ туйлд хүрнэ. Тансаг үнэр, гоёмсог өнгө бие биесдээ нэвчин шингэж нэгэн ер бусын сайхныг бүрдүүлнэ.

Яг энэ үеэр алтан гургалдай донгодож эхэлнэ. Өнгө, үнэр, дуу гурав нэгэн дор ийнхүү цогцлон жигдрэхэд мөнөөх ер бусын сайхны дутуу бүхэн тэгширч, орчлонгийн хосгүй гайхамшиг болон хувирна.

“Алтан Богдын шилд

Алтан гургалдай жиргэнэ

Алтан гургалдайн дуунд

Агт морьд сульдана.” хэмээх ардын дууны утга сая тайлагдаж, мартагдахын их далайг туулж ирсэн үвдис нь бишрэл төрүүлнэ.

Алтан гургалдайн дууны сайхныг үүнээс илүү уран хэлж боломгүй санагдан “Юутай гайхамшиг” хэмээн өөрийн эрхгүй уулга алдана.

Алтан гургалдайн жиргэх дуун сая сэтгэлийн гүнд хүрнэ. Ардын энэ дуу байгаагүй бол эх нутгийнхаа сайхнаас нэгийг нь би дутуу мэдрэх байж. Эх нутгийн сайхнаас нэгийг нь дутуу мэдэрсэн бол эгнэгт Монголоо гэх сэтгэл минь энэ л анзааны дутуу байх байж. Эцэг өвгөд маань ертөнцийн сайхан юм үзэж, сайхан юм сонсож, ариун сайхан үйл бүтээж явахыг урт наслахын үндэс гэж үздэг. Урт насалж гэмээн эх нутгийнхаа гайхамшигийг гүйцэд мэдэрч, эцэг өвгөдийн үлдээж өгсөн өвийг арвижуулж хойч үедээ өгнө.

Хангай дэлхий цэцэглэхэд үнэр дутсан бол алтан гургалдай жиргэхгүй байх байсан. Алтан гургалдай жиргээгүй бол ардын дуу гарахгүй байх байсан. Ардын дуу байгаагүй сэн бол эх нутаг гэж байхгүй байх байсан. Эх нутаг гэж байхгүй байсан бол амиа өгөх юм надад байхгүй байх байсан. Амиа өгөх юм байхгүй байсан бол амьдрал гэгч утгаа алдах байсан.

Юм бүхэн хоорондоо үндэс мөчир хоёр шиг холбоотой. Салгаж болшгүй өнө мөнхийн хэлхээтэй.

/Д.Батбаяр/

1. Яагаад “Өнө мөнхийн хэлхээ” гэж нэрлэх болсон бэ?
 - A. Өнгө, үнэр, дуу гурав нэгэн дор цогцолсон учраас
 - B. Орчлонгийн юм бүхэн үндэс мөчир хоёр шиг холбоотой учраас
 - C. Зуны дунд сард хангай дэлхий хамгийн үзэсгэлэнтэй болдог учраас
 - D. Алтан гургалдайн дуунд агт морьд сульддаг учраас
 - E. Ардын дуу өнө эртнээс мартагдахгүй ирсэн учраас
2. Эхийн дэвшүүлэн тавьсан асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.
 - A. Ардын дууны тухай
 - B. Урт наслахын үнэ цэнийн тухай
 - C. Эх нутгийн тухай
 - D. Амьдралын жам ёсны тухай
 - E. Ер бусын сайхны тухай
3. Эхийн гол санаанд **холбогдолгүй** хэсгийг олоорой.
 - A. Амиа өгөх юм байхгүй байсан бол амьдрал гэгч утгаа алдах байсан.
 - B. Алтан Богдын шилд алтан гургалдай жиргэнэ.

18. “Эх нутаг гэж байхгүй байсан бол амиа өгөх юм надад байхгүй байх байсан.” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.
- A. ялган дуудах
 - B. төсөөлөн барагцаалах
 - C. салган онцлох
 - D. дурсан дурдах
 - E. батлах
19. Олон тооны дагавар зөв хэрэглэснийг олоорой.
- A. мянга гаруй ажилчид
 - B. хүүхдүүдэд бэлэглэх
 - C. бөхчүүд барилдах
 - D. зарим асуудлууд
 - E. хэсэг хүүхдүүд
20. “насал-” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой.
- A. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.
 - B. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
 - C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.
 - D. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.
 - E. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад шууд бичнэ.
21. Буруу бичсэн бүлэг үгийг олоорой.
- A. харагдснаас, маллаа, авчихаад
 - B. харчхаад, эмээллэлээ, товчилвол
 - C. хүргээнэ, моджино, олгочхоосой
 - D. түлхэхээр, түүхчдийг, нөхцөлөөр
 - E. өгүүлбэрийг, уулзалтанд, тооцуулашгүй
22. Цэгийн оронд тохирохыг нь сонгоно уу.
Өгүүлбэр төгссөн хэдий ч санаагаа бүрэн гүйцэд илэрхийлж чадалгүй орхисныг илтгэхэд..... хэрэглэнэ.
- A. таслалтай зураас
 - B. цэгтэй таслал
 - C. цуваа цэг
 - D. зураас
 - E. давхар цэг
23. Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн дүрслэлээс уншаад, улиралтай нь зөв харгалзуулсныг олоорой.
- | | |
|---|----------|
| 1. Хангайн бороо гэнэт асгах нь сайхан
Харанхуйн дунд цахилгаан гялбах нь сайхан | a. өвөл |
| 2. Цайдам хоолой цайвалзаж цанхиртах сайхан
Цаад уулс гялс гялсхийн харагдах нь сайхан | b. хавар |
| 3. Ургамал цэцэг ургаж ногоорох нь сайхан
Утасны мод хөхөрч гандах нь сайхан | c. зун |
| 4. Наран шаргалтаж тоорогтох сайхан | d. намар |

- A. 1a, 2d, 3b, 4c
- B. 1b, 2a, 3c, 4d
- C. 1c, 2b, 3d, 4a
- D. 1b, 2c, 3a, 4d
- E. 1c, 2a, 3b, 4d

24. “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” зохиолд дарааллаараа тохирох хэсгийг олоорой.

- Балай их уувал биш үү
Бага зэрэг уувал биш үү
Балмад их согтвол биш үү
Үргэлж уувал биш үү
- A. улиг, жаргал, өвчин, галзуу
 - B. жаргал, өвчин, улиг, галзуу
 - C. галзуу, улиг, жаргал, өвчин
 - D. өвчин, жаргал, галзуу, улиг
 - E. өвчин, галзуу, улиг, жаргал

25. “Солонгын долоон өнгө билээ

- Идээний таван амттан билээ
Ижил нь үгүй үнэртэн билээ
Ид шидийн үзэсгэлэн билээ.” гэсэн нь ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?
- A. Сэгс цагаан богд /Д.Пүрэвдорж/
 - B. Дөрвөн цаг /Д.Нямсүрэн/
 - C. Дэлхий /Б.Явуухулан/
 - D. Монголын их амар амгалан /Ц.Бавуудорж/
 - E. Миний монгол /Р.Чойном/

26. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

- A. Есөн гүүтэй хүн хотын ах.
Есөн жигээтэй хүн саахалтын ах.
- B. Есөн хүүтэй хүн хотын ах.
Есөн жигээтэй хүн сахалтын ах.
- C. Есөн хүүтэй хүн худын ах.
Есөн зээтэй хүн саахалтын ах.
- D. Есөн гүүтэй хүн хотын ах.
Есөн цэгээтэй хүн сахалтын ах.
- E. Есөн хүүтэй хүн хотын ах.
Есөн зээтэй хүн саахалтын ах.

ᠡᠰᠡᠨ ᠭᠦᠦᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠬᠣᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠵᠢᠭᠡᠭᠡᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠰᠠᠬᠠᠯᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠬᠦᠦᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠬᠣᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠵᠡᠡᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠰᠠᠬᠠᠯᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠬᠦᠦᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠬᠣᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠴᠡᠭᠡᠭᠡᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠰᠠᠬᠠᠯᠲᠤᠨ ᠠᠬᠤ.ᠡᠰᠡᠨ ᠬᠦᠦᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠬᠣᠲᠤᠨ ᠠᠬᠤ.
ᠡᠰᠡᠨ ᠵᠡᠡᠲᠡᠢ ᠬᠦᠨ ᠰᠠᠬᠠᠯᠲᠤᠨ ᠠᠬᠤ.

27. Тийн ялгалын нөхцөлийг **буруу** дагуулсан хэсгийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

28. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

29. “-уул²” бүтээвэр залгахад аль нь өвөрмөц бичигдэх вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

30. Зөөлөн дэвсгэрээр төгссөн үгийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

31. “Зан авир” гэсэн холбоо үгийн онцолсон үг аль нь вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

32. Буруу бичсэн үгийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

33. “бөө удган” гэсэн холбоо үгийн онцолсон үг аль нь вэ?

- A.
بھھھھھھھھ
- B.
بھھھھھھھھ
- C.
بھھھھھھھھ
- D.
بھھھھھھھھ
- E.
بھھھھھھھھ

34. “үйлдвэрлэл” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой.

- A.
بھھھھھھھھھھ
- B.
بھھھھھھھھھھ
- C.
بھھھھھھھھھھ
- D.
بھھھھھھھھھھ
- E.
بھھھھھھھھھھ

35. Бүх үгийг зөв бичсэн хэсгийг олоорой.

- A.
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
- B.
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
- C.
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
- D.
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
- E.
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ
بھھھھھھھھھھ

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.
 - 2.1. Хэлцийн утгыг тунгаан, цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

<ol style="list-style-type: none"> a. Хөөрхий Гармаагийн удирдана гэж юу байх вэ. гэдэгтэй ижил юм болно биз. в. гэдэг шүү дээ. Хор үршиг дагуулах хэрэг гэдгийг нь би гадарласан нь зөв байж. с. Ээжийг одоо буц даа гэдэг юм уу. Ээж ч гэгчээр чамайг орхиод явж чадахгүй, одоо дуусахын хооронд гэнэ л дээ, мэдэж байна. d. гэгчээр одоо чи сүржигнэж гүйгээд яах вэ дээ. Бүх юм дууссан. 	<ol style="list-style-type: none"> 1. Могойн цус тэнгэрт 2. Үхрийн сүүлэн дээр хутга 3. Суусан газраасаа шороо атгана 4. Ниргэсэн хойно нь хашхирах
--	---

е. Одоо би хөдөөний ажлаас айхаа нэгэнт 5. Мах барагдахад богтос
 больсон. Энд хүрч ирээд хэчнээн их юм хийж ахлах
 болохыг ойлгосон. гэгч л болсон доо.

2.2. Аман зохиолын жишээг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------|--|
| a. зүйр цэцэн үг | 1. Хамба торго хээгүй
Ханчин сувд нүхгүй. |
| b. магтаал | 2. Харуулын ирээр өөлж хийсэн
Хамаг амьтныг хашиж тогтоосон
Хаалга түүнийг мялаая. |
| c. ерөөл | 3. Хөөрхөн халиун долгин шүү
Хөлд нь сууж бариарай. |
| d. ардын дуу | 4. Жаран хоёр соёотой
Хүдэр хүрэн шинжтэй
Баян буурал Алтай дэлхий. |
| e. оньсого | 5. Буурлаас үг сонс.
Болсноос ам хүр. |

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3
a	Эр үгэнд “-ы” бичих үг	дарш	баяр	будаг
b	Зөөлний тэмдэг “и” болох үг	тахь + чих	хумь + чих	хорь + чих
c	Ялгах эгшиггүй үг	тана	цутгалан	дүгнэлт
d	“-на ⁴ ” нөхцөлийг шүүд залгах үг	бүрх + нэ	хуул + на	хөлд + нө
e	Эр үгэнд “-ий” бичих үг	тарга	сандал	тараг

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|----|--------------|
| a. | 1. дуу чимээ |
| b. | 2. шар өнгө |
| c. | 3. шар үхэр |
| d. | 4. мах шарах |
| e. | 5. ер шир |

СОНСОХ ДААЛГАВАР

Гүйцэтгэх хугацаа: 15 минут

[10 оноо]

Санамж:

- “Магнай хээр” эхийг сонсохын өмнө асуултыг гүйлгэн уншаарай.
- Эхийг анхааралтай сонсоод асуултад хариулаарай.
- Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудсан дээр /36 -40/ зааврын дагуу будаарай.
- Зөв хариулт бүр 2 оноотой.

36. Аавын наадамд унадаг гоёлын морь аль нь вэ?
- A. Хээр үрээ
 - B. Магнай хээр
 - C. Номхон хээр
 - D. Монхор зээрд
 - E. Уургын морь
37. Магнай хээр гэж нэрлэх болсны шалтгаан юу вэ?
- A. Уурга барьсан хэн нэгэн морьтой хүн нэг цойлуулчихвал гүйцэгддэггүй учраас
 - B. Адууны түрүүнд толгой хаялан дүүхэлздэг учраас
 - C. Хээрийн бэлчээрт ч гэсэн гараар баригддаг учраас
 - D. Үргэж бусгах, хазаж хайрахыг мэдэхгүй буянтай амьтан учраас
 - E. Хөөж гүйцэхгүй морь, уургалж дийлэхгүй адүү үгүй болсон учраас
38. *“Одоохондоо яах вэ. Үүрэглэсэн, ялаанд шавуулсан л амьтан харагдаж байгаа байх. Худлаа даа, их амьтан болно, та нар харж л байгаарай”* гэсэн өгүүлбэрийн санаанд тохирох хэлц аль нь вэ?
- A. Даахин доороос хүлэг, дахан доороос эр.
 - B. Өнгө нь наанаа, өргөс нь цаанаа.
 - C. Эр өсөж, эсгий сунана.
 - D. Эр хүн зорьсондоо, эмээлт морь харайсандаа.
 - E. Даахитай малыг өргөс дагана, даарьтай малыг шаазгай дагана.
39. Эхэд дурдсан дараах үйл явдлуудын аль нь Монхор зээрдэд холбогдох вэ?
- A. Өч төчнөөн давируулж байж сүүл шарван цогьдог.
 - B. Ааваас эмээн дуртай дургүй унаж, хонь хурга эргүүлнэ.
 - C. Одоо л энүүгээр чинь уургын морь хийж авахгүй бол хождох нь.
 - D. Уурга барьсан хүний бараа хармагц үргэн давхиж чавхдан алга болно.
 - E. Над шиг шавил эр эргэхэд нь хийсэж уначих гэж байна лээ шүү.
40. Эхийн гол санаанд **холбогдолгүй** хэсгийг олоорой.
- A. Ямар ч амьтныг нэг, унаатай залгуулаад шүү байвал хаа вэ дээ.
 - B. Аавын хэлдгээр их амьтан гэдэг ийм байдаг ажээ.
 - C. Та нар чинь яачихсан монголгүй улс вэ.
 - D. Хээр үрээ шиг номхон юм ч ааван сааван олдохгүй дээ.
 - E. Айл гэдэг чинь уургын морьтой байж гэмээн унаатай явдаг юм байгаа биз дээ